

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд хийсэн дотоод аудитын дүнг хэлэлцсэн тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А-14 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс”-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан, дүгнэлтийг танилцуулав.

1. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2. дахь заалт, Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг зөрчиж нэр бүхий 24 аж ахуйн нэгжтэй байгуулсан **Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны гэрээ, газар ашиглах гэрээг цуцалж** холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах нь зүйтэй гэж дүгнэв. Энэхүү дүгнэлт нь дараах зөрчлүүдээр үндэслэгдсэн болно. Үүнд:

1.1 Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Гэрээ байгуулах тухай” А-01 дугаар тушаал нь Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Бүсийн удирдлага, зохион байгуулалт болон газар ашиглалтын нийтлэг журам”-ын 3.3-д заасан бүсэд газар эзэмшиж, ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, эсхүл дуудлага худалдаа явуулах арга замыг ашиглан олгох гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Газар олгох, төсөл сонгон шалгаруулахдаа Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын холбогдох заалтуудыг баримтлаагүй зөрчил гаргасан байна. Тухайлбал, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын тэгш, шудрага оролцоог хангах тухай 2.1.1. дэх заалт, сонгон шалгаруулалт явуулах дарааллыг заасан 5.1. дэх заалт, олон нийтэд 60-аас доошгүй хоногийн өмнө зарлан мэдээлэх тухай 7.1. дэх заалт, төсөл хүлээн авахдаа тэмдэглэл үйлдэх, тэмдэгтийн хураамж авах тухай 8.2, 8.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.3 Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Ж.Энхжаргал нь төсөл сонгон шалгаруулахдаа 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1001 тоот албан бичгээр хүсэлтээ илэрхийлэн “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-иар дүгнэлт гаргуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын төсөл шалгаруулах ажлын хэсгийг томилох тухай 9.1. дэх заалт, ажлын хэсгийн дарга нь бүсийн захирагчийн ажлын албаны дарга байна гэсэн 9.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

1.4 Төслийн сонгон шалгаруулалтад оролцогчдын талаар дүгнэлт гаргуулахаар “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-д хүргүүлсэн 01/1001 тоот албан бичиг нь хавсралтгүй /албан бичгийн бүртгэлд/ 1 хуудас байгаа нь төслүүдийн талаар ямар нэг мэдээлэл хүргэхгүйгээр үндэслэлгүй дүгнэлт гаргуулсан байна.

1.5 Сонгон шалгаруулалтад оролцох төслийн материалууд 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хооронд Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд ирсэнээр бүртгэгдсэн боловч дүгнэлт гаргуулахаар “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-д хүргүүлсэн талаарх албан бичиг, баримт алга байгаа нь тус компаний 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 1/98 тоот албан бичгээр Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд ирүүлсэн дүгнэлт нь үндэслэлгүй байна.

1.6 Төсөл сонгон шалгаруулалтын шаардлагад нийцэж байгаа тухай “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-ны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 1/98 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлт нь дээрх журмын үндсэн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангасан тухай оноогоор дүгнэсэн тухай мэдээлэл агуулаагүй байгаа нь төслийг сонгон шалгаруулж харгалзах оноог тавина гэсэн журмын 9.8. дахь заалтыг зөрчсөн байна.

1.7 Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Ж.Энхжаргалын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А-01 дугаар бүхий “Гэрээ байгуулах тухай” тушаал гарах хүртэлх хугацаанд тус байгууллагын албан хаагчид төсөл сонгон шалгаруулалтын талаар ямар нэг мэдээлэл аваагүй бөгөөд сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцоогүй байна. Харин тушаалаар өгөгдсөн үүргийг биелүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулсан эсэхийг нягтлахгүйгээр хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны, газар эзэмших ашиглах гэрээг байгуулж хэрэгжилтийг зохион байгуулсан нь хууль, тогтоомж зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн **А-110 дугаар тушаалыг хүчингүй болгож** хууль, тогтоомжид нийцүүлэн шинээр батлуулахаар шийдвэрлэв. Энэхүү шийдвэр нь дараах зөрчлүүдээр үндэслэгдсэн болно. Үүнд:

2.1 Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2016 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А-110 дугаар тушаалын 3 дугаар заалт нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.1-т “Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна” гэсэн заалт, уг хуулийн 20.2-т “Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар эрх олгосон Засгийн газрын гишүүн хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Мөн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын дээрх тушаалын хоёрдугаар хавсралтаар “Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсэд хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээ”-ны загварыг баталсан нь Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 3.1 дэх заалтаар үүрэг болгосон эрх хэмжээг хэтрүүлэн гаргасан шийдвэр байна.

3. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Д.Энхжаргал нь нэр бүхий 24 аж ахуйн нэгжид газар олгох үйл ажиллагааг зохион байгуулахдаа Авилгын эсрэг хуулийн 6.1.5-д заасан үүргээ биелүүлж ажиллаагүй, сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, ил тод явуулаагүй нь албан тушаалын эрх мэдлээ ашиглан бусдад давуу байдал олгож, бусдын эрхийг хязгаарлаж тус хуулийн 7.1.3-д заасан зөрчлийг гаргасан байна.

4. Дотоод аудитын тайланд тусгагдсан “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны эд хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хадгалалт хамгаалалт хангалтгүй, өөрийн орлогыг данс бүртгэлд бүрэн тусгадаггүй, байгууллагын захирлын тушаал эрх зүйн акт баримт бичгүүд нь бичиг хэргийн стандарт шаардлагыг хангаагүй, Халх гол төслийг хүлээж авах үйл ажиллагааг одоо болтол зохион байгуулаагүй зэрэг зөрчил дутагдлуудыг арилгах талаар шуурхай арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.

Дотоод аудитын дүгнэлтийг хэлэлцээд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолыг зөрчиж гарсан Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаагийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 110 дугаар тушаалыг хүчингүй болгох тушаалын төсөл боловсруулж танилцуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар /, Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/ нарт даалгасугай,

2. Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолыг зөрчиж гарсан Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаагийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 110 дугаар тушаалыг боловсруулсан болон хянасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-д үүрэг болгосугай,

3. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Ж.Энхжаргалын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А-01 дугаар бүхий “Гэрээ байгуулах тухай” тушаалыг боловсруулсан болон хянасан, холбогдох гэрээнд гарын үсэг зурсан албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллахыг Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа /Т.Жамбалцэрэн/-д үүрэг болгосугай,

4. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Ж.Энхжаргал нь нэр бүхий 24 аж ахуйн нэгжид газар олгох үйл ажиллагааг зохион байгуулахдаа дүгнэлт гаргах эрх зүйн чадамжгүй “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-иар дүгнэлт гаргуулсан, Авилгын эсрэг хуулийн 6.1.5-д заасан үүргээ биелүүлж ажиллаагүй, сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, ил тод явуулаагүй нь албан тушаалын эрх мэдлээ ашиглан бусдад давуу байдал олгож, бусдын эрхийг хязгаарлаж тус хуулийн 7.1.3-д заасан зөрчлийг гаргасан байх тул холбогдох хуулийн байгууллагад хандаж шалгуулахыг Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/-д үүрэг болгосугай,

5. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны олгосон газар олголт болон бусад холбогдох мэдээллийг УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Засгийн газрын хуралдаанд танилцуулах асуудлыг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Тамгын газарт хүргүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар /, Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа /Т.Жамбалцэрэн/ нарт даалгасугай,

6. Хүнс, хөдөө аж, ахуйн сайдын 2016 оны А-91 дүгээр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны санхүүжилтийн эх үүсвэр, өмч хөрөнгийн ашиглалтын асуудлыг тодорхой тусгах, Халх гол төслийн нэгжийг татан буулгах, эзэмшиж ажиглаж байсан хөрөнгийг холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/ нарт хариуцуулсугай.

7. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсд Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2. дахь заалт, Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг зөрчиж Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлаар ажиллаж байсан Ж.Энхжаргалын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А-01 дугаар бүхий “Гэрээ байгуулах тухай” тушаалаар нэр бүхий 24 аж ахуйн нэгжид олгосон газар болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.1; 20.2 дахь заалтуудыг зөрчиж байгуулсан “Хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээ”-г цуцлах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хуулийн хэлтсийн дарга /Б.Батцэцэг/, Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа /Т.Жамбалцэрэн/ нарт үүрэг болгосугай.

8. Хавсралтад дурдсан “Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа /Т.Жамбалцэрэн/-д даалгасугай.

9. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч, биелэлтийг дотоод аудитын хороонд тайлагнахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Совд/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

П.СЭРГЭЛЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Дотоод аудитын хороо”-ны 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн удирдамжийн дагуу Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үр дүнг сайжруулах, түүний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор дараах дотоод аудитын зөвлөмжийг хүргүүлж байна.

Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд:

1. Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд заасан хугацаанд Загвар аж ахуйг хүлээн авч холбогдох эрх зүйн шийдвэр гаргуулах;
2. Мөн загвар аж ахуйг хүлээж авахаас өмнө Загвар аж ахуй баригдсан газрын эзэмшлийн асуудлыг бүрэн шийдвэрлэх талаар БСШУЯ болон холбогдох газарт санал хүргүүлэх;
3. Халх гол төслийн нэгжийн хаалтын балансыг гаргаж, өмч хөрөнгийг холбогдох байгууллагад шилжүүлэх талаар шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
4. Загвар аж ахуйн хөрөнгийн өмчлөл, эзэмшилт, ашиглалт, үйл ажиллагаа хэвийн явуулах зардал, хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэх;
5. Халх гол төслийн нэгжийг татан буулгах арга хэмжээ авах;
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан орон тооны хязгаарыг хатуу мөрдөж ажиллах;
7. Санхүү төсвийн холбогдолтой хууль, дүрэм, журмыг бүрэн мөрдөж ажиллах;
8. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг баталсан шийдвэрийг дагаж, мөрдөх;
9. Ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулж, батлагдсан зааврын дагуу байгууллагын бүтцийн нэгжийн Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг боловсруулж, баталгаажуулах;
10. Ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын ангилал, зэрэглэлийг зөв тогтоох зорилго, зорилт чиг үүргийг тодорхойлох, давхардлыг арилгах;
11. Удирдах албан тушаалтнаас гарч буй шийдвэрийг холбогдох дүрэм, журам, стандартын дагуу зөв баримтжуулах;
12. Захиралын тушаалын хууль, эрх зүйн үндэслэл, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
13. Архивын тухай хууль болон Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан Байгууллагын архивын үндсэн зааврын дагуу нөхөн бүрдүүлэлт хийх;
14. Хууль, тогтоомжид нийцүүлэн албан хаагч тус бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;
15. Тариалан эрхлэлтийг дэмжих сантай 2016 оны 09 сарын 20-ны өдрөөр тооцсон 962.302.127.96 төгрөгийг үлдэгдэл өртөг бүхий хөрөнгийн гэрээг шинэчлэн хийж, эзэн хариуцагчийг тодорхой болгох асуудлыг зохион байгуулах